

ЭРТНИЙ ОВГИЙН ШИНЭЭР ОЛДСОН ЗАРИМ ТАМГАНЫ ТУХАЙ

Х.ЕДИЛХАН

Нийгэм эдийн засгийн судалгааны төв, Баян-Өлгий аймаг

Тулхуур үг: тамга, хадны сүг зураг, хөшөө, овог аймаг, Алтай

Өгүүллийн товч агуулга: Тус өгүүлэлд Баян-Өлгий аймгийн нутгаас шинээр олдсон эртний тамга тэмдгийг Монгол орны бусад газраас олдсон тамгуудтай харьцуулан үзээд тэдгээрийн он цагийг тогтоох оролдлого хийлээ. Шинээр илрүүлэн олсон 39 тамга тэмдгийн нэг хэсэг хүрэл, төмрийн түрүү үе, нөгөө хэсэг нь түрээгийн үед холбогдох бололтой.

Монгол Алтайн хадны зурагтай газруудыг хайж олох тархац, байршлыг тодорхойлох судалгааны явцад хад чулуунаа сийлсэн эртний тамга тэмдгүүдийг тусад нь бүртгэж байсныг нэгтгэн үзэхэд 39 төрлийн тамганы цуглуулгатай болсон байна (Едилхан 2005).

Шинээр олдсон тамга тус бүрийг монголын археологийн дурсгалын тамгатай адилтгаж үзэхэд ижил байна (Пэрлээ 1976) (Хүснэгт 1).

Байршил тодорхойлолт:

1. Цэнгэл сумын нутагт байдаг Алтан толгой хэмээх газар нь Ховд гол ба Цагаан голын бэлчирт орших жижиг толгой юм. Эндээс бид олон тооны хадны сийлмэл зураг, 100 гаруй булш хиргисүүр, 20 чулуун хөшөө, 5 хүн чулуу хөшөө шинээр илрүүлэн олсны дотор зэрэгцүүлэн босгосон том жижиг 2 чулуун хөшөөний зүүн талын хөшөөнд хоёр, мөн Алтан толгойн өмнө талд тусгай жижиг толгойн хаднаа олон тооны янгир, чоно зэрэг ан амьтдын дүрстэй цуг 3 төрлийн тамга сийлснийг тус тус тэмдэглэн бүртгэлээ.
2. Цэнгэл сумын нутаг Хурган нуурын баруун талын эрэгт орших “4 баатрын хөшөө” гэж нэрлэж заншсан (4 хүн чулуу) хүн чулууны хойт талын дөрвөлжин хэлбэртэй булшны чулуун хашлаганд сийлсэн тамга нь Улаанхус сумын Алхам хэмээх газарт байдаг чулуун хөшөөний хойт талд сийлсэн тамгатай ижил төстэй байна.
3. Бугат сумын нутаг Хар үзүүр хэмээх газарт орших дөрвөн тал нь 50-60 см тэгш хэмжээтэй сүрлэг чулуун хөшөөний баруун талд ирмэг дөхүүлж руни бичиг, дунд хэсэгт 3, мөн хойд талд 1, хөшөөний дөрвөлжин хашлаганд 1 нийтдээ 5 төрлийн тамга сийлжээ (Баяр, Эрдэнэбаатар 1999).

Хүснэгт 1. Шинээр олдсон тамганы дүрсүүдийг Монголын археологийн дурсгалд буй тамганы дүрстэй дүйлэх нь

	Тамга олдсон газрын нэр	Тамганы нэр	Шинээр олдсон тамганы дүрс	Монголын археологийн дурсгаланд буй тамга
1.	Цэнгэл. Алтан толгойн чулуун хөшөөнд			
2.	Мөн Алтан толгойн чулуун хөшөөнд	шудрага		
3.	Улаанхус. Алхамын чулуун хөшөөнд	элбэг хэмээх утагтай		
4.	Цэнгэл. Алтан толгойн хаданд			
5.	Мөн	ац		
6.	Мөн	ашамай (чагт)		
7.	Бугат. Хар үзүүр. Чулуун хөшөөнд	угалза		
8.	Мөн	илдэн		
9.	Мөн	дэгээ		
10.	Мөн	шилээвэр		
11.	Бугат. Хар үзүүр чулуун хөшөөний хашлагад	гогцоо (цагираг)		
12.	Цэнгэл. Билүүтийн хаданд	наран үсэмэл		
13.	Мөн	туурай		
14.	Мөн	наран		
15.	Цэнгэл. Хурган нуур 4 баатрын хөшөөний чулуун хашлаганд	“Элбэг” тамга (нэмрлэгтэй)		
16.	Цэнгэл. Билүүтийн А толгой хаданд	ац		

Хүснэгт 1. Үргэлжлэл

17.	Мөн	Хос харуул		
18.	Мөн	алхан		
19.	Мөн	саран		
20.	Мөн	алхам		
21.	Мөн	ац		
22.	Цэнгэл. Билүүтийн "Б" толгойн хаданд	нуман		
23.	Мөн	шилээвэр		
24.	Мөн	жадан		
25.	Мөн			
26.	Улаанхус. Бага ойгорын хаданд	Дөрвөлжин		
27.	Бугат. Хатуу хаданд	ацан		
28.	Мөн	ац (саран)		
29.	Бугат хатуу чулуун хөшөөнд			
30.	Мөн	саран		
31.	Мөн			
32.	Мөн			
33.	Мөн	ац		
34.	Мөн			
35.	Мөн			
36.	Мөн			
37.	Мөн			
38.	Цэнгэл. Шивээт-хайрхан . Хүн уулууны ар талд			
39.	Цэнгэл. Шивээтхайрхан. Чулуун хөшөөний хажуу талд			

4. Цэнгэл сумын нутаг Билүүт хэмээх газарт хоорондоо ойр орших 3 толгойд эртний хүн олон тооны хадны зураг сүг сийлжээ. Энд гурван хэсэг газар бүлэг олон ан амьтдын дүрстэй цуг нэлээд хэдэн тамга сийлжээ.
5. Улаанхус сумын Бага ойгор гэдэг газар хүний зам хөлийн ойролцоо хавтгай чулуунаа дөрвөлжин хэлбэртэй сийлсэн дүрсийг эртний овгийн тамга бололтой гэж үзлээ (Цэвээндорж нар 2003).
6. Бугат сумын нутаг Хатуу хэмээх газар нь сумын төвөөс өмнө зүг 40 км алслагдсан мөнх цастай уулаар хүрээлэгдсэн гүнзгий хавцал, хад чулуу ихтэй байгалийн сонин тогтоцтой нутаг юм. Хатуугийн гол Ховд голд цутгах бэлчрээс эх хүртэл 30-гаруй км үргэлжилж голын хоёр талын хөндийд олон тооны булш хиргисүүр, чулуун хөшөө, хадны зураг, сүг тархсан эртний соёлын өв, археологийн дурсгалаар баялаг нутаг. Хатуугийн хаданд хоёр хэсэг газарт орших чулуун хөшөөдийн ар талд 9 төрлийн, бүгд 11 төрлийн тамга сийлсэн байна.
7. Цэнгэл сумын нутаг Шивээтхайрхан уулын зүүн сугад олон тооны булш хиргисүүр, чулуун хөшөө, 3 хүн чулуу нэг доор орших эртний дурсгалтай газар бий. Энд чулуун хөшөөний хажуу талд мөн нэгэн хүн чулууны ар талд тус бүр тамганы дүрс сийлжээ.

Он цагийн асуудал:


Тухайн дурсгалыг хэдийд сийлж үлдээснийг тэр газарт олдсон зэвсэг багажийн үлдэц, булш хөшөө дурсгал, малтлагын явцад илрэн олдсон эд өлгийн зүйлс зэргийг харьцуулан шинжин судалсан судалгааны үр дүнгээр тодорхойлж болох юм (Аргынбаев нар 2000). Гэвч дурсгалтай газруудыг дээрх аргаар судалсан хэрэглэгдэхүүн одоохондоо үгүй тул дүрс тэмдгийг дэлхийн газар бүхэнд сайн мэдэгдсэн чулуу сийлэлтийн оньсон арга техник, мөн тэндхийн дурсгалт зүйлс, сийлмэл зураг сүг зэргийн байдлаар жишиж харьцуулан ажиглаваас он цагийг баримжаалан хэлж болохоор байна (Цэвээндорж 1999). Тамга тэмдэг сийлсэн дурсгалуудыг харьцуулан жишиж үзэхэд он цагийн хувьд хоорондоо тасалдангуй мэт сэтгэгдэл төрүүлэх боловч, энэ хавийн булш, бусад хад чулууны зураг сүг, тамга тэмдэг зэрэг нь түүхийн үе бүрд янз бүрийн овог аймаг оршин сууж байсныг харуулж буй бололтой.

Бидний сонирхуулан танилцуулж буй тамгадын дүрс зурлага, их төлөв эгэл жирийн дүрс хэлбэртэй байх тул нилээд эрт үед холбогдох байх гэж үзэж байна. Энэ талаар ажиглагдсан зарим шинж тэмдэгүүдийн талаар доор товч танилцуулъя. Бугат

сумын Хар үзүүрийн чулуун хөшөөн дээрх бичээсийг судлаачид эртний түрэг бичиг гэж үздэг байна. Уг хөшөөнд сийлсэн тамга, дээрх бичээстэй нэгэн цаг үеийн дурсгал гэвэл түрэгийн үетэй холбогдуулж болох юм. Харин хөшөөний хойт талд сийлсэн угалз, дөрвөлжин хашилганд сийлсэн “гогцоо” тамга нь дээрх бичээс, тамгадаас эрт сийлсэн байж болох талтай. Эндээс холгүй орших Хатуугийн хаднаа сийлсэн хоёр янзын ацан, мөн энэ хавийн чулуун хөшөөдийн ар талд сийлсэн олон төрөл тамгадыг эндэхийн булш хадны сийлмэл зургийг хийсэн аргатай харьцуулан үзэхэд хүрэл, төмрийн түрүү үетэй холбогдуулж болохоор байна.

Хурган нуурын хүн чулууны хойт талын дөрвөлжин чулуун хашлаганд сийлсэн тамгыг Алхамын чулуун хөшөөний хойт талд сийлсэн тамгатай зэрэгцүүлэхэд дан үүсгэмэл тамга мөн болох нь мэдэгдэхийн зэрэгцээ энэ хоёр дурсгал хоорондоо цаг хугацааны хувьд хол зөрүүтэй байгаа нь хонхойлон сийлсэн байдал, хадны өнгөнөөс илэрхий юм. Шийвэгхайрхан уулын чулуун хөшөө ба хүн чулуунд сийлсэн тамганы сийлэлтийн байдал үүнтэй ижил бөгөөд хүн чулууны хойт талд сийлсэн тамгыг түрэг, чулуун хөшөөний хажуу талд сийлсэн тамгыг төмрийн зэвсгийн түрүү үетэй холбогдуулан үзэх саналтай байна.

Билүүт. Алтан толгойн хаднаа сийлсэн ба бусад үлдсэн тамга тэмдгүүдийг эндхийн олон тооны хадны сийлмэл зургуудтай жишиж үзэхэд хүрэл ба төмөр зэвсгийн



түрүү үетэй холбогдох бололтой. Эдгээр тамгадын дотроос бид нэгэн төрөл тамганы талаар өгүүлье. Билүүтийн хаднаа сийлсэн туурай тамганы он цагийг тодорхойлохдоо хамтад нь дүрсэлсэн сийлмэл зураг сүгтэй жиших нь зүйтэй гэж үзлээ. Зургаан туурай тамгыг гол дүрсээр нь сонгон онцгойлон үзүүлэхийг хичээхдээ аргамаг хүлэг ба морьтой хүний дүрсийг туслах дүрээр сонгон эдгээр дүрсүүдийг хооронд нь шууд холбон сийлж утга санаагаа илэрхийлжээ гэлтэй (Зураг 1).

Зураг 1. Билүүтийн хаднаа сийлсэн туурай тамга

Туурай тамгыг томоор дүрсэлснээс үзэхэд Монгол Алтай нутагт наран ба түүнээс үүсгэмэл тамгыг өмчилдөг хоёр овогтныг бүрэлдэхүүндээ багтаасан овгийн холбоо оршин тогтнож байжээ гэж үзэх тал бий.

